

Дулааны цахилгаан станцад ахмад сайн дурын гишүүн томилон ажиллуулах (Сайн дурын гишүүн илгээх хөтөлбөр)

Сайн дурын гишүүний тухай

Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц нь Монгол улсын нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээний 70 хувь, Улаанбаатар хотын төвийн дулааны хангамжийн 65 хувийг хангадаг Монгол улсын хамгийн том дулааны цахилгаан станц юм. Уг станцыг 1983 оноос хуучнаар ЗСБНХУ-ын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар ажиллуулж эхэлсэн бөгөөд энэхүү хамтын ажиллагаа зогссоноос хойш Япон улсын Засгийн газраас тусламжийн үйл ажиллагааг явуулах болсон. 2008 оноос хойш тус станцад ахмад сайн дурын гишүүн илгээх шугамаар 4 инженер томилогдон ажиллаад байна. Тэдний нэг болох Ясүмото Акихиро нь термодинамик, дулаан дамжуулалтын технологиор баклавар, магистрийн зэрэг хамгаалсан бөгөөд Хитачигийн үйлдвэрт ажиллаж байхдаа гадаадын орнуудын цахилгаан станцын гэрээ хэлцэл, түүнийг барьж байгуулахтай холбоотой ажлыг 30 гаруй жил хийж ирсэн нэгэн билээ. Тэрээр гавьяаныхаа амралтанд гарсаныхаа дараа өнөөг хүртэлх цахилгаан эрчим хүчний талаарх мэдлэг

туршлагаа гадаадын орнуудын цахилгаан станцын хөгжил дэвшилд зориулъя хэмээн шийдэж, 69 настайдаа JICA-ийн ахмад сайн дурын гишүүний хөтөлбөрт хамрагдсан байна. Тэрээр 2008~2010 оны хооронд 2 жилийн хугацаатай дулааны IV цахилгаан станцын даргын ажлын албаны төлөвлөлтийн хэлтэст менежмент, удирдлагыг сайжруулах зөвлөхөөр ажиллаж байсан.

2 жилийн томилгоот хугацаагаа дуусгасны дараа тэрээр “Ажлын хүнд хэцүү нөхцөлд эрчим хүчний салбарыг бүхий л чадлаараа авч явж буй нийт ажилчдын хүчин зүтгэл, тэвчээр хатуужлыг бишрэн хүндэтгэж байна. Мөн цахилгаан станцын инженер техникийн залуу ажилчид улам бүр чадваржиж, өсөн дэвжиж буй нь надад ажлын урам зориг хайрласан билээ. Цахилгаан станцын ажилчидтай мөр зэрэгцэн Монгол улсын зүрх болсон эрчим хүчний салбарын төлөө хүчин зүтгэх нь надад оноогдсон үүрэг байлаа” хэмээн сэтгэгдлээ хэлсэн юм.

Дөрөвдүгээр цахилгаан станцад хэрэгжүүлсэн төслүүд

- Ахмад сайн дурын гишүүн томилж ажиллуулах (Техникийн хамтын ажиллагаа: 2008~өнөөг хүртэл) (Менежмент/удирдлагыг сайжруулах, нунтагласан нүүрсний бойлерын шаталтыг сайжруулах, нөөцийн менежмент, бойлерын хяналтын төхөөрөмжийн тохиргооны технологи)
- Улаанбаатар хотын IV цахилгаан станцыг засч сайжруулах төсөл (1~2-р шат) (Буцалтгүй тусламж) (Тоосон системийн элэгдэлтийн эсрэг авах арга хэмжээ, үнс зайлуулах системийн бөглөрөлийн эсрэг авах арга хэмжээ, цахилгаан шүүлтүүрийн шинэчлэл, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг сайжруулах арга хэмжээ, цахилгаан шүүлтүүрийн шинэчлэл, сүлжээний халуун усны системийн тоноглол зэрэгт шаардлагатай нийт 2.8 тэрбум иений буцалтгүй тусламж үзүүлсэн)
- Улаанбаатар хотын IV цахилгаан станцыг засч сайжруулах төсөл (1~2-р шат) (Иений хөнгөлөлттэй зээл) (8 бойлер (1~8-р бойлер)-ыг бүрэн автоматжуулж шууд шаталтын системтэй болгох 10.6 тэрбум иений хөнгөлөлттэй зээл)



Дулааны IV цахилгаан станц



Монгол инженер ЖАЙКА-ийн ахмад сайн дурын ажилтан Ясүмотогийн хамт